



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 1114

Арвайхээр

Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд
авсан зарим хязгаарлалтыг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 07, 2021 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт (Ковид-19) цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хязгаарласан аймгийн төвөөс сумд руу орох, гарах хөдөлгөөнийг 03 дугаар сарын 14-ний 15.00 цагаас эхлэн нээсүгэй.

2. Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулиудын танхимиын давтлага, төв барааны зах, худалдааны төвүүд, такси үйлчилгээ, спорт заал, фитнесс, усан бассейн, үсчин, гоо сайхан, гандан хийд, хоолны газар, ресторан зэрэг үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 14-ний 15.00 цагаас, аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 03 дугаар сарын 15-наас эхлэн хэвийн горимд шилжүүлсүгэй.

3. Хужирт суманд үйл ажиллагаа явуулж буй рашаан сувиллуудад өөрийн аймгийн сумдуудаас болон халдварт бүртгэгдээгүй аймгуудаас ирэх иргэдийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, халдварт хамгааллын дэглэмийг баримтлан үйл ажиллагаагаа хэвийн явуулахыг зөвшөөрч, халдвартын тохиолдол илэрсэн хот, аймгуудаас сувилуулагч хүлээн авахыг хориглосугай.

4. Улсын онцгой комиссын шийдвэрээр нийслэлээс орох гарах хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүртэл хязгаарласантай холбогдуулж Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрээс Улаанбаатар хотруу орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06.00 цаг хүртэл хязгаарлаж, эрүүл мэнд, албан томилот, буяны ажил, хүнс, шатахуун, тулээ нүүрс, малын тэжээлийн тээвэр зэрэг шалтгаанаар иргэдийг аймгийн Шуурхай штабын тусгай зөвшөөрлийн дагуу хот хоорондын хөдөлгөөнд оролцуулсугай.

5. Хязгаарлалт тогтоосон хугацаанд иргэдийг байнга оршин суух хаягтаа зорчих нөхцөлийг бурдүүлж нэг удаа зорчихыг зөвшөөрсүгэй.

011100254

2.

6. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад бүртгэл хяналтын системийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

7. Баян-Өндөр, Сант, Баянгол сумдын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах зорилгоор Баян-Өндөр суманд хяналтын цэг байгуулж, ажиллах албан хаагчдыг томилгоожуулж ажиллахыг дээрх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ